



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 01/63

Арвайхээр сум

**Зардал хуваарилах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 15/06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 24 тусгагдсан Богд, Бүрд, Арвайхээр хотын Тэмүүлэл-Эрдэм, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Хархорин сумын Гүнзгий сургуульд физик, Богд сумын 1, 2 дугаар сургууль, Бүрд, Төгрөг, Уянга сумын 1 дүгээр сургууль, Хайрхандулаан, Хархорин сумын 2 дугаар сургууль болон Гүнзгий, Номын хүрдэн сургуулиудад химийн кабинетын тоног төхөөрөмжид зарцуулагдах 160,000,000 (нэг зуун жаран сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0145

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар  
сарын 09-ны өдрийн 415 дүгээр  
захирамжийн хавсралт



**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН КАБИНЕТИЙН ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мянган төгрөг)
1	Богд, Бүрд, Арвайхээр хотын Тэмүүлэл-Эрдэм, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Хархорин сумын Гүнзгий сургуульд физикийн кабинет	70,000.0
2	Богд сумын 1, 2 дугаар сургууль, Бүрд, Төгрөг, Уянга сумын 1 дүгээр сургууль, Хайрхандулаан, Хархорин сумын 2 дугаар сургууль болон Гүнзгий, Номын хүрдэн сургуулиудад химийн кабинет	90,000.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>160,000.0</b>

-oOo-